



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 27

№ 01/88 АУА-2018/11/СА-ТЦЭ

Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Хулд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний материалыг батлагдсан орц нормын дагуу бодож олгоогүй, хяналтгүй зарцуулсан 443,470.80 /дөрвөн зуун дөчин гурван мянга дөрвөн зуун далан төгрөг наян мөнгө / төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 4 сарын 08-ны өдрийн 113 тоот тушаалаар батлагдсан /Цэцэрлэг сургуулийн насны хүүхдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэм хэмжээ, дэглэм"-д тогтоосон нормативыг баримтлаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./ гэж заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан жишиг хэмжээг баримтлан зарцуулалт хийх;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Хулд сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Ц.Туяацэцэг, нягтлан бодогч Х.Батжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР

Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ

Ц.ТУЯАЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

Х.БАТЖАРГАЛ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.